

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

Монгол улсад шударга ёс, хариуцлага, хөгжил цэцэглэлийг төлөвшүүлэхийн төлөөх хамтрагч

ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТӨЛӨӨХ ОРОЛЦОГЧДЫН ҮЙЛ ЯВЦЫГ ОРОН НУТАГТ ДЭМЖИЖ БАЙНА

“Хэрэв уул уурхайн компаниуд олборлолт хийж дууссаныхаа дараа газарт нөхөн сэргээлт хийхгүй бол бид лицензийг нь хүчингүй болгох буюу шинэ лиценз олгохгүй” хэмээн Баянхонгор аймгийн засаг дарга н.Зоригтбаатар мэдэгджээ. Энэ бол ажлын байр, ашиг орлогын хувьд уул уурхайн компаниудаас ихээхэн хараат байдаг аймгийн Засаг даргын хэлсэн хатуухан үг байлаа. Уул уурхайн компаниудын явуургүй үйл ажиллагаа, олборлолт явуулсны дараа газарт нь нөхөн сэргээлт хийхгүй байгаатай холбогдон Улаанбаатарт төдийгүй орон даяар ийм үгс сонгогдох болсоор удаж байгаа билээ.

Баянхонгор аймагт одоогоор мэдэгдэж буй 47 компани 70 лиценз эзэмшин уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн зарим нь харьцангуй том ихэнхи нь жижгэвтэр компаниуд аж. Засаг дарга хэлэхдээ, Баянхонгор аймагт илүү олон томоохон компаниуд үйл ажиллагаа явуулаасай гэж хүсэж байна. Тэдний үйл ажиллагаанд хяналт тавихад хялбар төдийгүй тэд ажилчдынхаа аюулгүй байдал, үйл ажиллагааныхаа зарчим, арга барилд ихээхэн анхаардаг гэв. Гэвч энэ нь бас бүх том компаниуд тийм гэсэн үг биш аж. Тиймээс Засаг дарга олборлолт явуулж байгаа уул уурхайн компаниудын хариуцлагыг нэмэгдүүлэхээр компаниудтайгаа гэрээ байгуулж эхэлсэн байна. 2007 онд нийтдээ 15 лиценз олгосноос 8 компани нь сайн дурын гэрээнд гарын үсэг зуржээ. Үүний үр дүнд 2007 онд хийгдсэн физикийн болон биологийн нөхөн сэргээлтийн хэмжээ нэмэгджээ.

2007 оны 12-р сарын 6-нд Баянхонгор аймагт ХУУ-н төлөөх оролцогчдын уулзалт семинарыг Хонгор нутгийн дуудлага хөдөлгөөн, тэргүүн Б.Батболд нарын идэвхтэй оролцоотойгоор орон нутгийн хэмжээнд зохион байгуулав. Семинарт оролцсон Засаг дарга, ИТХ-ын дарга, Засгийн газрын төлөөлөл болон албаны хүмүүс өөрсдийн үзэл бодол, саналаа илэрхийлэв. Хонгор нутгийн дуудлага хөдөлгөөний тэргүүн Б. Батболд нь “Монгол нутаг мину” (МНМ) эвслийн удирдах зөвлөлийн 5 гишүүний нэг юм.



“Бид гол мөрнөө хамгаалахыг хүсч байна. Цаашдаа хяналт тавихад хүндрэлтэй олон жижиг уурхайнуудын оронд цөөн том уурхайнууд үйл ажиллагаагаа явуулаасай” гэж Баянхонгор аймгийн Засаг дарга н.Зоригтбаатар хэлэв.

УМХГ-ын орон нутгийн салбар, Байгаль орчны яам, орон нутгийн хөдөлгөөнүүдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийнхэн, нутгийн иргэд оролцов. Өөр өөр ашиг сонирхлыг төлөөлсөн оролцогчдын үйл явц хөдөө орон нутагт хэрхэн хүрээгээ тэлэн өргөжиж буйг семинар харуулав. Засаг дарга н.Зоригтбаатар “ХУУ төлөөх оролцогчдын үйл явц орон нутаг руу үйл ажиллагаагаа өргөжүүлэх ажил Баянхонгор аймгаас гараагаа эхэлж байгаад нэн талархаж байна” хэмээн бахархан хэлсэн юм.

Засаг дарга болон бусад албаныхан ХУУ-г төлөвшүүлэх, хөхиүлэн дэмжихэд тулгарч буй бэрхшээл, хүндрэлүүдээ тэмдэглэж нутгийнхаа хөдөлгөөнийхэн, ард иргэдэд хандаж байлаа. Тухайлбал, T&G компани Баянхонгорт 2004 оноос хойш олборлолт хийж байгаа боловч нэг ч удаа нөхөн сэргээлт хийгээгүй, компаний хэрэг шүүхэд шилжсэн боловч нөхөн сэргээлтийн норм стандарт байхгүй гэсэн үндэслэлээр уг хэргийг хүчингүй болгожээ.

МОНГОЛ УЛС

Азийн сан байгаль орчны эрүүл ахуй, хүн амын эрүүл мэндийг хамгаалах байдлаар байгалийн баялагийг хариуцлагатай ашиглах явдлыг хөхиүлэн дэмжихийн тулд төрийн, хувийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Баянхонгор аймагт нийт 325 лицензээс 70 лиценз эзэмшигч уул уурхайн үйл ажиллагаа явуулж байна.

Одоогоор Баянхонгор аймагт олборлолт хийгдсэн газрын 44,8%-д нөхөн сэргээлт ямар нэгэн байдлаар хийгдэж 2007 онд 195 га газар нөхөн сэргээлт хийгдсэн байх юм байна.

Онон-Улз хөдөлгөөний тэргүүн Л. Отгонцэцэг болон бусад хөдөлгөөнүүд лиценз эзэмших хүсэлтийг хянаж үзэх үйл явцад иргэдийг оролцуулж байх хүсэлт гаргасан бөгөөд 30 хоногийн тайлбар хийх хугацаа нь хангалтгүй болохыг тэмдэглэв. Иргэний нийгмийн бусад төлөөлөгчид ч засгийн газартай хамтран ажиллана гэдгээ илэрхийлсэн бөгөөд лиценз олгох үйл явц дахь иргэдийн оролцоог шийдвэрлэж өгөхийг хүссэн юм. Иргэд хянах үйл явцад оролцож болох боловч миний бие энэхүү асуудалд хариу өгөхөд хүчин мөхөсдөнө хэмээн засаг дарга мэдэгдсэн байна. Ашигт малтмалын хуулийн дагуу лиценз эзэмших хүсэлтийн хариуг аймаг 30 хоногийн дотор өгөх ёстой ажээ. Гэхдээ 30 хоногийн хугацаа нь АМГТХЭГ-аас аймагт шилжүүлснээр эхэлдэг байна. Шуудангийн үйлчилгээний саатлын улмаас ихэнхи тохиолдолд 30 хоногийн тайлбар хийх хугацаа нь тухайн бичиг баримт шуудангаар ирж байх үед дуусчихдаг аж.

Хуралд оролцогсод Баянхонгор аймаг төдийгүй улс оронд нүүрлээд байгаа өөр нэг чухал асуудал бол гар аргаар олборлогч нинжа нарын аюулыг онцлон тэмдэглэсэн юм. Томоохон уул уурхайн компаниудад бид анхаарлаа нилээд хандуулдаг ч шийдвэрлэвэл зохих өөр нэг асуудал бол нинжа нарын учруулж буй аюул хэмээн Аймгийн ИТХ-ын тэргүүн н. Ганхүлэг мэдэгдлээ. Ажлын байр дутмаг байгаагаас жижиг уурхай эрхлэх нь өсч, мөн аймгийн төв рүү нүүх шилжилт хөдөлгөөн ч маш хурдацтайгаар нэмэгдэж байгаа ажээ.

УМХГ-ын ажилтнуудын үзэж байгаагаар нинжа нар тус аймгийн 8 сумаар тархаад байна. Засаг даргын хэлснээр гар аргаар олборлолт явуулж буйн улмаас олон хүмүүс гэмтэж бэртэх эсвэл амь насаа алдах аюулд ч хүрч байгаа гэнэ. Нинжа нарын лагерьт гэмт хэрэг гарах нь элбэг, 20 гаруй газруудад нинжа нар мөнгөн ус, цианид зэргийн химийн хорт бодис хэрэглэсэн болох нь тогтоогдсон байна. Голын уснаас дээж авсан бөгөөд хариу нь хараахан гараагүй. Мөнгөн усанд хордсон хэд хэдэн тохиолдол илэрч тэдгээр хүмүүс нь орон нутгийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй аж. Хордлого нилээд хүнд, өргөн тархсан байсан учраас Засаг дарга орон нутгийн эмч нарыг сургахаар Улаанбаатараас эмч урьсан байна.

Тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагууд лиценз олгохоосоо өмнө холбогдох бичиг баримтыг нь сайтар шалгах хэрэгтэй. Лиценз олгосны дараа дахин өөрчлөн шинэчлэхэд хэцүү байдаг талаар Байгаль орчны хэлтсийн дарга яриу. “Хөдөлгөөнүүдийн идэвхитэй оролцоонд иргэд илүү итгэдэг бөгөөд үүний үр дүнд, нөхөн сэргээлтийг нэмэгдүүлэх зэргээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад нилээд ахиц гарч байна” гэв.

Аймгийн удирдлагууд 4 сард уул уурхайн компаниудтай уулзах бөгөөд тэр үед иргэний нийгмийн байгууллагуудтай гэрээ байгуулахыг Засаг дарга санал болгосон байна.

Баянхонгор аймгийн төвөөс 60 кмт орших Шаргалжуут рашаан сувилалд хийсэн 2 хоногийн семинар ийнхүү өндөрлөв. Хоёр хоногийн туршид оролцогчид орон даяар иргэдийн оролцоотойгоор Монголд ХУУ хөхиүлэн дэмжихэд гаргасан амжилт ололтоо эргэн дурсацагасан юм. Мөн МНМ эвсэл нь шинэ бүтэц, зохион байгуулалт, удирдлагын асуудлаа хэлэлцэж бодлого, стратегээ тодорхойлон гаргалаа.



МНМ эвслийн гишүүд Шаргалжуутын рашаан сувилалд 1 жилийн ойгоо тэмдэглэлээ Эвсэл нь орон даяар 10 гаруй мянган монголчуудыг төлөөлсөн нутаг усаа хамгаалах 11 хөдөлгөөнөөс бүрдэж байна. МНМ эвсэл бүх монголчуудын ашиг тусын төлөө ХУУ-г хөхиүлэн дэмжих үйл явцад иргэдийг төлөөлөн ажиллаж ирсэн юм.

МНМ эвслийн Удирдах зөвлөлийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр сонгов. Хэнтий аймгийн Онон-Улз хөдөлгөөний тэргүүн, МНМ эвслийн удирдах зөвлөлийн гишүүн Л. Отгонцэцэг “Засгийн газар болон уул уурхайн компаниудыг хариуцлагатай байлгахын тулд бид тэдэнтэй хамтран ажиллах болно” гэж онцлон тэмдэглэлээ.